

АРВАЙХЭЭР СУМЫН РАШААНТ 8 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА
Т.ГАНТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах”							
1.	1.1. Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх.	Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хувиар	90	90	Шинээр мөрдөгдөж байгаа хуулийн хяналт, бүртгэлийг нэмэгдүүлж, эзэнжүүлэх ажил тогтмолжиж байна. Аймгийн 4 дэд хөтөлбөрийн холбогдох заалт, багийн иргэдийн нийтийн хурлын 2 тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллалаа.	01-11	100
	1.2. “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлах, сул ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, аймаг, хотуудаас шилжин ирж байгаа өрхийн хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах, цахим хүсэлт, өргөдлийг шийдвэрлэх.	Иргэдэд хүргэсэн зарын тоогоор	3	5	Төрийн албаны салбар зөвлөлөөс зарлаж байгаа төрийн захиргааны сул орон тоог нөхөх, шилжүүлэн ажиллуулах зар болон Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран ажилладаг аж ахуй нэгжүүдийн нээлттэй ажлын байрны зарыг багийн раге хуудсанд байршуулах, иргэдтэй шууд холбогдож зар хүргэн ажлын байранд зуучлах замаар ажилласан. Төрийн албанд 1, хувийн хэвшилд 2 иргэн байнгын ажлын байранд орсон байна.	01-11	100
		Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар	90	90	Улаанбаатар хот болон өөр бусад аймгаас шилжин ирсэн 12 өрх байна. Эдгээр өрхүүдээс сургуулийн насны хүүхэд 5, цэцэрлэгийн насны 2 хүүхэд байгаа бөгөөд хүүхдүүдийг хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулж, 2 өрхийг зээл төсөл	01-11	100

		E-Mongolia шийдвэрлэлтийн хувиар	100	100	хөтөлбөрт хамруулав.	01-11	100
1.3	"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах.	Ногоон байгууламж нэмэгдүүлсэн өрхийн тоогоор	30	30	Хаврын мод тарилтаар 12 өрх, намрын тарилтаар 20 өрх хашаандаа агч, улиас, чацаргана тарьж нөхөн тарилтаар 21 ширхэг улиасыг Гандангийн зам дагуу тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.	01-10	80
1.4.	Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих	Шинээр хог хаягдлыг ангилан ялгах хогийн савтай болсон өрхийн тоогоор	4	2	Иргэдэд хог хаягдлыг ангилан ялгах талаар мэдээллийг хүргэж, 2 айл шинээр хог хаягдлыг ангилан ялгах жишиг хогийн савтай болсон.	01-11	100
		Сургалт, мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоогоор	60	20	Бүх нийтийн их цэвэрлэгээг багийн нутаг дэвсгэрт 2 удаа зохион байгуулж 67 иргэнийг оролцуулан 16 тонн хогийг төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Цэвэрлэгээнд хамрагдсан иргэдэд Хог хаягдлын тухай болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг сурталчлан таниулж мэдээлэл хийсэн.	01-11	100
1.5.	Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	1	"Угаадасгүй баг" хяналт шалгалтын ажлыг багийн хэмжээнд зохион байгуулж, шалгалтаар илэрсэн зөрчилд ахин ийм зөрчил гаргахгүй байх талаар холбогдох хууль тогтоомжийг сурталчлан ажилласан.	01-11	90
		Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн	1.8	30	2024 онд шахмал түлш үйлдвэрлээгүй. Энэ нь биднээс хамаарахгүй.	01-11	90

ерхийн хувиар							
1.6. Малчдын "Аравтын бүлэг"-ийг чадавхжуулах ажил зохион байгуулах, бүлгийн тоог нэмэгдүүлэх	Шинээр эко болон сайжруулсан нойл, муу усны цооногтой болсон өрхийн тоогоор	10	13	Эко нойл төсөлд 15 өрхийг хамруулахаар мөнгийг гүйцэтгэгч компанийн дансанд байршуулсан. Энэ онд 3 өрхийн нойлыг хийж, үлдсэн 12 нойлыг хавар хийхээр хүлээгдэж байна. Мөн 10 өрх нүхэн жорлонгоо засаж сайжруулсан.	01-12	100	
	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	1	Малчдын "Аравтын бүлэг"-ийн гишүүдийг "Шинэ хоршоо" хөдөлгөөний сургалтад хамруулж мэдээлэл хүргэсэн. Ингэснээр шинээр 7 өрх хоршоонд нэгдэж, үр шимийг нь хүртэж байна.	01-12	100	
	Чадавхжсан Аравтын бүлгийн тоогоор	-	-	Аравтын бүлэг байгаа ч чадавх сул. Дэмжлэг хэрэгтэй.	07-11	90	
	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	90	-	Өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулж, орлогч даргаар батлуулан хэрэгжүүлж байна.	07-12	90	
	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	-	50	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн төлөвлөгөөг сумын төлөвлөгөөтэй уялдуулан 3 зорилт, 16 арга хэмжээтэйгээр боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	01-11	90	
1.9.Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес эрхлэгчдийг төсөл хөтөлбөрийн сургалтад хамруулах, зуулчлах. Сул	Төсөл хөтөлбөрт зуучилж, сургалтад хамруулсан	1	2	Өмнөговь аймагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Сусгоби Сэндс" ХХК-ны өдөрлөг арга хэмжээнд ажил хайгч иргэдийг оролцуулсан. ХХҮГ-аар хувиараа хөдөлмөр	01-11	100	

ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх.	тоогоор				эрхлэгчдийг дэмжих төсөл хөтөлбөрт 6 өрх хамрагдаж, хэрэгжих шатандаа явж байна. ХХҮГ-аас зарласан малжуулах төсөлд 3 өрх дэмжигдсэн. “Сайхан монголын өнгө” ТББ-ын хүнсний ногоо тариалах төсөл хөтөлбөрт 3 өрхийг хамруулан, хяналт тавин ажиллалаа.	
Зорилт 2. “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах”						
2.	2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг ханган ажиллах.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	90	90	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байна. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль хийгдэж 42 иргэн, 6 техниктэйгээр ЕБ-ын I сургуулийн гадна талбайд цуглаж заавар, зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтад хамрагдсан.	01-11 80
	2.2. Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмай хороотой хамтран ажиллах.	Шинээр сайн дурын идэвхтэн гишүүнд элсүүлсэн иргэний тоогоор	5	5	Багийн Нийгмийн ажилтныг Улаан Загалмайн хорооны идэвхтэн гишүүнээр бүртгүүлж, Гамшгийн үеийн СЭМНС-ЗДэмжлэг үзүүлэх сургагч багшийн сургалтад хамруулсан.	01-12 100
	2.3. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах.	Гэрээний хэрэгжилтийн хувиар	90	90	“Түшиг-Дөлгөөн” ӨЭМТөвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилт 90 хувьтай.	01-11 90
		Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар	80	85	Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 2900 иргэдээс 1570 иргэн хамрагдсан байна. Артерийн гипертензи хамрагдвал зохих 1257 иргэн, үүнээс 429 иргэн буюу 34.1 хувьтай. Чихрийн шижин хамрагдвал зохих 1079 иргэн, үүнээс 480 иргэн буюу 44.4 хувьтай. Хөхний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих	01-11 90

					605 иргэн, үүнээс 281 иргэн буюу 46.4 хувьтай. Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих 151 иргэн, үүнээс 83 иргэн буюу 54.9 хувьтай. Элэгний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих 130 иргэн, үүнээс 17 иргэн буюу 13 хувьтай. А аминдэм уусан 6-59 сартай хүүхдийн тоо 280.		
2.4. Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах.	Гэрээний хэрэгжилтийн хувиар	90	50		Мал эмнэлгийн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хэрэгжилт 80 хувьтай.	01-12	80
2.5. Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах.	Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар	100	100		Хагас жилийн малын түүвэр тооллогоор тус багаас 25 малчин өрх сонгогдож, малын тоог холбогдох маягтын дагуу авч, мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан.	01-12	100
2.6. "Багийн хамтарсан баг"-ийн үйл ажиллагааны тухайн жилийн батлах, төлөвлөгөөг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	80	85		Багийн "Хамтарсан баг"-ийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 100 хувьтай.	01-12	100
2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	2	2		Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай. Архины эмчилгээнд 2 иргэнийг хамруулж, хордлого тайлах эмчилгээнд 5 иргэнийг хэвтүүлэн эмчлүүлээ. 332, 466 дугаар байрыг камержууллаа.	01-12	90

	2.8. Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, нэгтгүүлэх.	Мэдээний тоо	47	30	Тариалалтын болон ургац хураалтын мэдээ, төл бойжилтын мэдээг хөдөө аж ахуйн программд алдаагүй үнэн зөв шивж оруулсан.	01-12	100
	2.9. Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах.	Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлт хувиар	80	90	Шинээр томилогдсон нийгмийн ажилтныг шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган чиглүүлж, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллалаа.	10-12	100
	2.10. БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, биелэлтийг тайлагнах.	Зохин байгуулсан хурлын тоогоор	3	2	Багийн иргэдийн нийтийн хурал 2 удаа хуралдаж, нийт 7 тогтоол, 4 хурлын тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтөлж материалыг Арвайхээр сумын ИТХуралд уламжлав.	01-06	100
Зорилт 3. “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх”	3.1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах.	Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувиар	90	90	Иргэдээс цахимаар 256, цаасаар 81, нийт 337 санал гарсныг 2024.05.26-ны өдрийн БИНХурлаар эрэмбэлэн материалыг бүрдүүлж, Хотын захирагчийн албанд хүргүүлсэн.	01-06	100
	3.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгөх.	Шийдвэрлэлтийн хувиар	90	95	Тус багт ирүүлсэн 88 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн улирал бүр тайлан мэдээг сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллалаа.	01-11	100
	Зорилт 4. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”						

4.	4.1. Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх.	Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар	100	100	Тайлангийн хугацаанд нийт 98 албан бичиг ирснийг холбогдох ажилтанд шилжүүлэх, хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих зэргээр дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа.	01-11	100
	4.2. Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх.	Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар	100	100	Тайлангийн хугацаанд нийт 98 албан бичиг бусад байгууллагаас ирснээс хариутай 56 албан бичиг, шууд 42, хугацаа хоцорч шийдвэрлэсэн байхгүй.	01-11	100
	4.3. Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцох.	Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар	100	100	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3 дахь хэсэгт заасны дагуу ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх газрын (https://meduuleg.iaac.mn) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлсэн. Төрийн албанд ёс зүйн зөрчил гаргалгүйгээр ажиллаж байна.	01-11	100
		Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар	100	100	Ажлын цаг ашиглалтыг бүтээлч, үр ашигтай өнгөрүүлж, сахилга, хариуцлагыг дээшлүүлж тасалсан цаг байхгүй. Гадуур айл өрхөөр ажилласан цаг 240 байгаа нь өмнөх оноос 168 цагаар нэмэгдсэн үр дүн гарсан.	01-12	100
		Хамрагдсан арга хэмжээний тоогоор	3	3	Байгууллагаас зохион байгуулсан спортын арга хэмжээнд 1 удаа, Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан сургалт, тэмцээн уралдаанд 1 удаа тус тус идэвхийлэн оролцсон. Байгууллагаа төлөөлөн "Авлигалыг тэвчье, сэргийлье" аяны хүрээнд зохион байгуулагдсан "Дартсын тэмцээн"-д Арвайхээр сумын ЗДТГазрын 3 албан	01-11	100

					хаагчийн хамт оролцож, "Тэргүүн байр" эзэлсэн амжилтыг үзүүлсэн.		
4.4. Байгууллага, багт туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулах.	Арга хэмжээний тоогоор	1	-		Видео контент хийж бэлтгэсэн.	01-11	100
Зорилт 5. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт							
5.1 2024 оны УИХ-ын сонгуульд ялалт байгуулах	Ялалтын хувиар	80	60		УИХ-ын сонгуульд МАН-аас нэр дэвшсэн 9 нэр дэвшигчээс 6 буюу 66.6 хувийг ялуулсан.	01-10	100
5.2 2024 оны Орон нутгийн ялалт байгуулах	Ялалтын хувиар	88.8	65		Аймгийн ИТХ-ын сонгуульд өөрөө нэр дэвшиж 63 хувиар ялалт байгуулсан.	01-10	100

Зургаа. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	
1.	Хүний эрхийн чиглэлээр сертификаттай сургалтад хамрагдах	2 Сертификат гэрчилгээ авсан байна.	-	4	5	01-11	30
2.	Монгол бичгээр баримт боловсруулах чадварт суралцсан байна.	Баримт бичиг боловсруулалтын түвшингээр	-	Анхан шат	Суралцахад бэлэн.	01-11	50


Т.ГАНТУЯА /
(Нэр, гарын үсэг)

ТАЙЛАН ГАРГАСАН:
БАГИЙН ЗАСАГ ДАРГА
(Албан тушаал)

2024.11.25
(Огноо)